

## 2017 оны I улирлын төсвийн гүйцэтгэл

2017-04-15

Булган

2017 оны I улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр нийт орлого ба тусламжийн дүн 13,7 тэрбум төгрөг буюу 100,3 хувийн, нийт зарлага 12,5 тэрбум төгрөг буюу 78,2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Үүнээс:

### Нэг. Төсвийн орлогын бүрдүүлэлт:

Аймгийн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 13,7 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 35,4 сая төгрөгөөр буюу 0,3 хувиар давж биелсэн байна. Үүнээс татварын орлого 297,7 сая төгрөгөөр буюу 107,1 хувиар, урсгал орлого 34,8 сая төгрөгөөр буюу 100,7 хувиар тус тус биеллээ.

Төсвийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг орлогын төрлөөр авч үзвэл:

(мян.төг)

Орлогын нэр төрөл	Батлагдсан төсөв		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	зөрүү	Хувь
	жилээр	тайлант үе /өссөн дүнгээр/			
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>52,145,309.0</b>	<b>13,631,098.0</b>	<b>13,666,550.0</b>	<b>(35,452.0)</b>	<b>100.3</b>
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>18,135,722.4</b>	<b>4,027,984.1</b>	<b>4,325,725.9</b>	<b>(297,741.8)</b>	<b>107.4</b>
Орлогын албан татвар	4,418,116.2	844,199.4	674,667.8	169,531.6	79.9
Хувь хүний орлогын албан татвар	4,938,116.2	1,364,199.4	941,856.4	422,343.0	69.0
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	4,188,010.1	1,220,000.0	863,684.4	356,315.6	70.8
Үйл ажиллагааны орлого	269,183.4	41,626.6	17,912.9	23,713.7	43.0
Шууд бус орлого	480,922.7	102,572.8	60,259.1	42,313.7	58.7
Хувь хүний ОАТатварын буцаан олголт	(520,000.0)	(520,000.0)	(267,188.5)	(252,811.5)	51.4
Хөрөнгийн албан татвар	699,810.0	84,652.5	120,118.6	(35,466.1)	141.9
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	380,000.0	71,000.0	91,036.4	(20,036.4)	128.2
Бууны албан татвар	65,190.0	7,152.5	2,997.3	4,155.2	41.9
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	254,620.0	6,500.0	26,085.0	(19,585.0)	401.3
Бусад татвар, төлбөр, хураамж	13,017,796.2	3,099,132.2	3,530,939.4	(431,807.2)	113.9
Бусад нийтлэг төлбөр, хураамж	457,565.7	102,056.0	97,077.7	4,978.3	95.1
Улсын тэмдэгтийн хураамж	185,400.0	40,412.3	34,475.7	5,936.6	85.3
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	35,900.0	6,749.9	1,007.0	5,742.9	14.9
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	144,265.7	31,893.8	12,494.3	19,399.6	39.2

Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	90,000.0	23,000.0	49,100.8	(26,100.8)	213.5
Бусад татвар	2,000.0	-	-	-	-
Газрын төлбөр	321,000.0	17,000.0	33,307.9	(16,307.9)	195.9
Газрын төлбөр	221,000.0	17,000.0	18,307.9	(1,307.9)	107.7
Дуудлага худалдаа	100,000.0	-	15,000.0	(15,000.0)	-
<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	<b>12,237,084.5</b>	<b>2,979,662.2</b>	<b>3,400,553.8</b>	<b>(420,891.6)</b>	<b>114.1</b>
Ойн нөөц ашигласны төлбөр	372,736.1	37,480.2	25,341.0	12,139.2	67.6
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	14,190.0	1,882.0	2,129.0	(247.0)	113.1
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	11,848,958.4	2,940,300.0	3,373,017.7	(432,717.7)	114.7
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1,200.0	-	66.0	(66.0)	-
Бусад татвар	2,146.0	414.0	-	414.0	-
Нохойны албан татвар	2,146.0	414.0	-	414.0	-
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,087,192.4</b>	<b>660,908.8</b>	<b>398,040.2</b>	<b>262,868.6</b>	<b>60.2</b>
Хувьцааны ногдол ашиг	13,230.0	13,230.0	-	13,230.0	-
Торгуулийн орлого	415,800.0	62,346.9	76,220.3	(13,873.4)	122.3
Төсөв байгууллагын өөрийн орлого	2,554,862.7	564,631.9	306,155.5	258,476.4	54.2
Түрээсийн орлого	19,981.3	4,500.0	5,359.4	(859.4)	119.1
Бусад орлого	83,318.4	16,200.0	10,305.1	5,894.9	63.6
<b>Хөрөнгийн орлого</b>	<b>20,000.0</b>	<b>5,000.0</b>	<b>20,960.0</b>	<b>(15,960.0)</b>	<b>419.2</b>
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	20,000.0	5,000.0	20,960.0	(15,960.0)	419.2
<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>30,902,394.2</b>	<b>8,937,205.1</b>	<b>8,921,824.0</b>	<b>15,381.1</b>	<b>99.8</b>
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	28,925,368.6	8,672,630.6	8,672,630.6	-	100.0
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	1,977,025.6	264,574.5	249,193.4	15,381.1	94.2

- Хувь хүний орлогын албан татвар, бууны албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн хураамж, хог хаягдлын үйлчилгээний хураамж, ойн нөөц ашигласны төлбөр, ногдол ашиг 4,9-422,3 сая төгрөгөөр тасарч, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж, газрын төлбөр, ус рашааны нөөц ашигласны төлбөр, хөрөнгийн орлого, хүү торгуулийн орлого 13,8-432,7 сая төгрөгөөр тус тус давж биелжээ.
- Хувь хүний орлогын албан татварын хуульд заасны дагуу 547 хүнд 267,2 сая төгрөгийн буцаан олголт хийсэн байна. /4 сард 611 иргэнд 228,0 сая төгрөгийн буцаан олголт хийж, нийт 1158 иргэнд 495,2 сая төгрөг буцааж олгосон/

- Урсгал төсвийн орлогын гүйцэтгэлийг сумаар авч үзвэл Бүрэгхангай, Орхон, Сайхан, Сэлэнгэ, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сум 110,1-251,7 хувиар биелүүлж, бусад сумын орлогын төлөвлөгөө биелээгүй байна. Сумын урсгал орлого нийт дүнгээр 87,0 сая төгрөгөөр тасарч 73,0 хувийн гүйцэтгэлтэй гарсан.

**Хоёр. Төсвийн зарлага, санхүүжилт:**

Орон нутгийн төсвийн зарлага 4,7 тэрбум төгрөг буюу 68,5 хувь, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын зардал 7,8 тэрбум төгрөг буюу 88,1 хувийн гүйцэтгэлтэй гарлаа. Төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийг зарлагын эдийн засгийн ангиллаар авч үзвэл:

Зардлын эдийн засгийн ангилал	Батлагдсан төсөв		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	Хэмнэлт/хэтрэлт	
	жилээр	тайлант үе /өссөн дүнгээр/		дүн	хувь, %
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	57,953,285.6	15,974,518.3	12,491,062.7	3,483,455.6	78.2
НИЙТ ЗАРЛАГА	55,419,777.0	15,320,986.1	12,451,442.8	2,869,543.3	81.3
УРСГАЛ ЗАРДАЛ	50,958,769.5	14,069,491.8	12,191,701.3	1,877,790.5	86.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39,457,621.9	9,966,249.1	8,558,753.3	1,407,495.8	85.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,437,256.7	5,640,834.9	5,386,334.7	254,500.2	95.5
АО-оос НД-д төлөх шимтгэл	2,471,966.1	621,460.6	584,530.3	36,930.3	94.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,232,534.1	1,911,423.2	1,573,787.6	337,635.6	82.3
Хангамж, бараа материалын зардал	668,868.4	192,189.7	146,251.0	45,938.7	76.1
Нормативт зардал	2,405,864.4	673,117.2	357,012.1	316,105.1	53.0
Эд хогшил, урсгал засварын зардал	139,430.0	26,813.3	15,170.1	11,643.2	56.6
Томилолт, зочны зардал	140,823.0	55,121.5	38,152.4	16,969.1	69.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	309,347.2	121,542.9	67,610.4	53,932.5	55.6
Бараа үйлчилгээний бусад зардал	5,651,532.0	723,745.8	389,904.7	333,841.2	53.9
ТАТААС	37,462.0	3,000.0	2,000.0	1,000.0	66.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,463,685.6	4,100,242.7	3,630,948.0	469,294.7	88.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,461,007.5	1,251,494.3	259,741.6	991,752.7	20.8
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЗЭЭЛ	2,533,508.6	653,532.2	39,619.9	613,912.3	6.1

Нийт зарлагын 47.8 хувь буюу 5970.9 сая төгрөгийг цалин, НДШ-д, 12,6 хувь буюу 1573,8 сая төгрөгийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 19.4 хувь буюу 2422.1 сая төгрөгийг нийгмийн халамжийн үйлчилгээ болон ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж урамшуулалд, 20.2 хувь буюу 2524.3 сая төгрөгийг хангамж бараа материал, нормативт зардал, албан томилолт зэрэг бусад зардалд тус тус зарцуулсан байна.

2017 оны 3 сард тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 8672,6 сая, суманд 1208,9 сая, аймгийн төсвийн шууд харьяа байгууллагуудад 2266,7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг тус тус олгосон. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, аймгийн Байгаль хамгаалах сан, Замын сангийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгож байгаа болно. Орон нутгийн хөгжлийн сангаас 249.2 сая төгрөгийн

орлогын шилжүүлэг ирснээс 40.6 сая төгрөгийг Булган сумын Хот тохижилт үйлчилгээний анги, 50,0 сая төгрөгийг мал эмнэлгийн үйлчилгээний зардалд шилжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө төлөвлөгөөний дагуу 121889,0 мянган төгрөгийн санхүүжилт авч шагнал урамшуулал, буцалтгүй тусламж, болзошгүй зардал, Ахмадын хорооны үйл ажиллагааны санхүүжилтэнд 73896,0 мянган төгрөг зарцуулж 60,6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийгмийн халамжийн санд 1,2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, халамжийн тэтгэвэр 1017 хүнд 406,9 сая, нөхцөлт мөнгөн тусламж 1409 хүнд 253,0 сая, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж 1335 хүнд 162,8 сая, ахмад настанд үзүүлсэн тэтгэмж тусламж, хөнгөлөлт 241 хүнд 40,6 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт 60 хүнд 7,9 сая, жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй эхэд олгосон тусламж 1427 хүнд 133,8 сая, хүнс тэжээл нийгмийн халамжийн хөтөлбөрт 3115 хүнд хамруулж 25,8 сая төгрөгийн санхүүжилт олгож 87,6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийт авлага 38,2 сая, өглөг 247,8 сая төгрөг байна. Нийт өглөгөөс цалин, НДШ-ийн өр 71,3 сая төг, халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир усны өр 117.4 сая, эмийн өр 13.3 сая, албан томилолт 11.8 сая, бусад зардлын өглөг 34,0 сая төгрөг байна.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС